

## Бугат сумын Соёлын төвд хяналт шалгалт хийсэн тухай

### **Хяналт шалгалтын зорилго**

Булган аймгийн засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын баталсан 2017 оны 10 сарын 09-ны өдрийн 01/19 дугаар удирдамжийн дагуу санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон бусад холбогдох дүрэм, журам, тушаалуудын хэрэгжилтыг хангуулах, үндсэн үйл ажиллагааны байдал, зохион байгуулалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааны байдлыг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх, ололт амжилтыг бататгаж, зөрчил дутагдлыг арилгахад оршино.

### **Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа**

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ц.Алтанхуяг  
2017 оны 10 дугаар сарын 09-өөс ажлын 7 хоног

### **Шалгалтанд хамрагдсан байгууллага, объектын нэр**

Бугат сумын Соёлын төвийн 2015, 2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаа хамрагдав.

### **Шалгалтанд хамрагдсан объектын талаарх**

#### **товч мэдээлэл**

Булган аймгийн Бугат сумын 3-р багт байршилтай Соёлын төв нь 5 ажиллагсадтай ба үүнээс эрхлэгч 1, номын санч 1, хөгжмийн багш 1, бүжгийн багш 1, үйлчлэгч 1 гэсэн орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

2015 оны 01 сарын 01-нээс 2016 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл 1-р гарын үсгийг дарга Э.Одхүү, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Б.Дагийсүрэн, С.Нямсүрэн нар зурсан ба төрийн санд бүртгэлийн 040235090 /2015, 2016 онд/ тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох “СТS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

### **Өмнөх шалгалтын талаар**

Булган аймгийн Аудитын газраас тус газрын 2015, 2016 оны 01 сарын 01-ээс 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна гэж тус тус дүгнэжээ.

### **Шалгалтын явцад хийгдсэн ажил, шийдвэрлэсэн асуудал**

Тус байгууллагын 2015-2016 оны касс, харилцахын баримт, няравын тайлан, нягтлан бодох бүртгэлийн журнал, даргын тушаал, цалин олгох хүснэгт, нийгмийн даатгалын болон татварын, санхүүгийн тайлан, 2015, 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын газрын дүгнэлт зэрэг баримт материалуудад тулгуурлан эрхлэгч асан Э.Одхүү, нягтлан бодогч Б.Дагийсүрэн, нягтлан бодогч асан С.Нямсүрэн нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийлээ.

Санхүүжилт, орлогын талаар:

2015 онд төсвөөс 43783,9 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн ба 44499,9 мянган төгрөг авч өөрийн орлогоор 486,0 мянган төгрөг төсөвт оруулж үйл ажиллагааны зардалд 44985,9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2016 онд төсвөөс 45274,3 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн ба батлагдсаны дагуу авч өөрийн орлогоор 692,5 мянган төгрөгийг төсөвт оруулж үйл ажиллагааны зардалд 45966,8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын тайлангаар:

2015 оны үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 219664,5 мянган төгрөг дээр хандиваар ирсэн караоке машин болох 1100,0 мянган төгрөгний тоног төхөөрөмж нэмэгдэж жилийн эцэст 220764,6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 13027,5 мянган төгрөг дээр 1149,7 мянган төгрөгийн аж ахуйн материал, 210,5 мянган төгрөгний түлш, шатах тослох материал худалдан авч 588,4 мянган төгрөгний аж ахуйн материал, 210,5 мянган төгрөгний түлш, шатах тослох материал үйл ажиллагаандаа зарцуулж оны эцэст 13588,8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

2016 оны үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 220764,6 мянган төгрөг дээр нэмэгдэж хасагдаагүй жилийн эцэст 220764,6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 13588,8 мянган төгрөг дээр 1335,9 мянган төгрөгний аж ахуйн материал, 93,0 мянган төгрөгний түлш, шатах тослох материал худалдан авч 957,4 мянган төгрөгний аж ахуйн материал, 93,0 мянган төгрөгний түлш шатах тослох материал үйл ажиллагаандаа зарцуулж оны эцэст 13967,3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй баланс гаргасан байна.

Өглөг, авлагын талаар: 2015 онд Цалинд 258,1 мянган төгрөг, бичиг хэрэгт 34,0 мянган төгрөг, тээвэр шатахуунд 142,6 мянган төгрөг, байгууллагад 67,0 мянган төгрөг, хүмүүст 320,0 мянган төгрөг нийт 821,7 мянган төгрөгний өртэй, авлаггүй тайлан гарсан байна. 2016 онд өглөг, авлагагүй тайлан баланс гарсан байна.

Төсөвт зардлын талаар /мян.төг/

2015 онд төсөвт зардлыг 45552,3 мянган төгрөгөөр төлөвлөсөн, өөрийн орлого 486,0 мянган төгрөг нэмэгдэж, гүйцэтгэлээр 44985,9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын 73,7 хувь буюу 33156,3 мянган төгрөгийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 8,2 хувь буюу 3696,7 мянган төгрөгийг ЭМНДШимтгэл, 6,5 хувь буюу 2937,7 мянган төгрөгийг түлш халаалт, 4,2 хувь буюу 1874,0 мянган төгрөгийг уран бүтээлийн зардалд тус тус зарцуулсан байна.

2016 онд төсөвт зардлыг 47042,7 мянган төгрөгөөр төлөвлөсөн, өөрийн орлогоор 692,5 мянган төгрөг нэмэгдэж, гүйцэтгэлээр 45966,8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2016 онд нийт төсвийн зардлын 70,0 хувь буюу 32167,8 мянган төгрөгийг цалин хөлс нэмэгдэл урамшуулалын зардалд, 8,0 хувь буюу 3686,8 мянган төгрөгийг ЭМНДШимтгэлийн зардалд, 10,8 хувь буюу 4998,2 мянган төгрөгийг түлш халаалтын зардалд, 5,3 хувь буюу 2449,3 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд тус тус зарцуулсан.

### **Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, шалтгаан**

1. Орлого, зарлагын баримтад хүлээн авсан, хүлээлгэн өгсөн хүний гарын үсэггүй, бэлэн мөнгөний гүйлгээний тайланг нягтлан бодогч шалгаж хүлээн авч гарын үсэг зураагүй, шатахууны тайланг дутуу гаргасан, жолоочийн тооцооны хуудсийг хөтлөөгүй, тайланд орлого, зарлагыг хавсарган ,баримтын тоог бичээгүй, агуулахын бүртгэл хөтөлдөггүй, томилолтын тооцооллыг хийж гарын үсэг зурж тамга дарж баталгаажуулдаггүй байгаа зэрэг нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно./, мөн хуулийн 13.5-д /Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно./ заасан заалтуудыг зөрчиж байна.

2. Цалингийн тооцооны хүснэгт болон гарт олгох хүснэгт дээр гарын үсэг зурж баталгаажуулдаггүй

3. Тус байгууллагын Эрхлэгч Э.Одхүү, нягтлан бодогч Б.Дагийсүрэн нар нь 2015 оны 04 сарын 21 нд шатахууны үнэ болох 46500 төгрөг, 2015 оны 05 сарын 21 нд 21500 төгрөг нийт 67900 төгрөгийг иргэн С.Цасанбаатарын ХААН банк дахь 5273058522 тоот дансанд шилжүүлсэн боловч материалын орлого зарлагын тайлан, жолоочийн тооцооны хуудас байхгүй, ямар ажилд хэрэглэсэн нь тодорхойгүйгээр санхүүгийн тайланд зардал болгон тусгасан байгаа нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./, 13.7-д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./ заасан заалтуудыг зөрчсөн байна.

4. Шалгалтаар тус байгууллагын Эрхлэгч асан Э.Одхүү, нягтлан бодогч Б.Дагийсүрэн нар нь байгууллагын даргын 2015 оны 07 сарын 01 ны өдрийн 04 тоот тушаалаар 2015 оны 07 сарын 01 нд 2015 оны баяр наадмын үйл ажиллагаанд зориулж 364500 төгрөгийг бэлэн мөнгөний хүсэлтээр төсөвт байгууллагуудын бэлэн мөнгөний данс болох ХААН банк дахь 5273001245 тоот дансанд шилжүүлж уг данснаас тус байгууллагын номын санч, нярав П.Гүндэгмаа нь авч байгууллагын касс орлого авсан боловч мөнгөн кассын тайланд юунд зарцуулсан талаар тусгаагүй, нягтлан бодогч тайланг авч хянаагүй, ямар зүйлд зарцуулсан анхан шатны баримтгүйгээр санхүүгийн тайланд зардал болгон тусгасан байгаа нь Сангийн сайдын 2012 оны 12 сарын 21-ний өдрийн 276 тоот тушаалаар баталсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журмын 2.7-д /Мөнгөн кассын санхүүгийн баримт нь засваргүй, үнэн зөв хөтлөгдөж,

баримтын бүрдлийг хангасан байх ба зарлагын төлбөр гүйцэтгэх эрхийг олгосон албан ёсны шийдвэрт үндэслэгдэн цохолт хийгдсэн байна./, Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./, 13.7-д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./ заасан заалтуудыг зөрчсөн байна.

5. Шалгалтаар тус байгууллагын Эрхлэгч асан Э.Одхүү, нягтлан бодогч асан С.Нямсүрэн нар нь байгууллагын даргын 2016 оны 09 сарын 09 ны өдрийн 04 тоот тушаалаар 2016 оны 09 сарын 09 нд техник хэрэгсэл пульт гэрэл гэрэлтүүлэг засварлахад зориулж 300000 төгрөгийг бэлэн мөнгөний хүсэлтээр төсөвт байгууллагын бэлэн мөнгөний данс болох ХААН банк дахь 5273001245 тоот дансанд шилжүүлсэнг номын санч, нярав П.Гүндэгмаа нь эрхлэгч асан Э.Одхүүд 2016 оны 09 сарын 13 ны өдөр гарын үсэг зуруулан 300000 төгрөгийг өгсөн боловч ямар зүйлд зарцуулсан нь тодорхойгүй, анхан шатны баримтгүйгээр санхүүгийн тайланд зардал болгон тусгасан байгаа нь Сангийн сайдын 2012 оны 12 сарын 21-ний өдрийн 276 тоот тушаалаар баталсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журмын 2.7-д /Мөнгөн кассын санхүүгийн баримт нь засваргүй, үнэн зөв хөтлөгдөж, баримтын бүрдлийг хангасан байх ба зарлагын төлбөр гүйцэтгэх эрхийг олгосон албан ёсны шийдвэрт үндэслэгдэн цохолт хийгдсэн байна./, Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./, 13.7-д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./ заасан заалтуудыг зөрчсөн байна.

6. Шилэн дансны нэгдсэн сайтад Соёлын төв нь 2017 оны 3-р улиралын байдлаар 109 мэдээлэл байршуулахаас 108 мэдээлэл байршуулж 1 мэдээлэл огт мэдээллээгүй, 13 мэдээлэл хоцроож мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.2-д /Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 сарын 25-ны өдрийн дотор, сар, улиралын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор/, мөн хуулийн 8.2-д /Төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ/ заасан заалтуудыг зөрчсөн байна.

**Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа,  
зөвлөгөө өгсөн байдал**

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар улсын байцаагчийн 3 актаар 732400 төгрөгийн төлбөр тогтоов.

Зөрчил дутагдлыг арилгуулж, таслан зогсоох зорилгоор 2 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

**Дүгнэлт**

Тус хэлтэст Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7 дахь заалтууд, Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн нөхөх заавар”-ын 2 дугаар зүйлийн 4.НХМаягт МХ-5 маягтын хэрэгжилт хангалтгүй байна.

Анхан шатны баримтуудын гарын үсгийн бүрдэл дутуу, кассын тайланг нярав дутуу хийсэн, нягтлан бодогч шалгаж хүлээн аваагүй, кассын дэвтрийг шаардлага хангахгүй хөтөлсөн, агуулахын бүртгэл хөтлөөгүй, шатахууныг хэтрэлт, хэмнэлтээр тооцож акт үйлдээгүй, материалуудыг ангилж бараа материал нэг бүрээр тайлан гаргаагүй зэрэг байгаа нь байгууллага дотооддоо бүртгэлээр тавих дотоодын хяналт хийгдээгүй, ажлын хариуцлага сул байна гэж дүгнэлээ.

### **Цаашид авах арга хэмжээний санал**

1. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, улсын байцаагчийн актаар тогтоогдсон төлбөрийг хугацаанд нь барагдуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөөг биелүүлж ажиллах.

2. Дотоодын хяналт шалгалтыг сайжруулж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх.

БИЧСЭН:

САНХҮҮ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ

Ц.АЛТАНХУЯГ